



НАРИЙНТЭЭЛ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.18 № 285
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад
нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4 дэх хэсэгт заасны дагуу Төрийн аудитын байгууллага Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Нарийнтээл сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Нарийнтээл сумын Монгол ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Нарийнтээл сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Нарийнтээл сумын Монгол ардын намын хорооны Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Нарийнтээл сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (...хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нарийнтээл сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ – АЖИЛ ОРЛОГОТОЙ ИРГЭН

- 1.1 Өрхийн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 1.2 Иргэдэд өрхийн орлогыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх чиглэлийн бүх төрлийн сургалт, сурталчилгаанд хамруулах
- 1.3 Ажлын байр, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор төрөл бүрийн жижиг дундын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
- 1.4 Иргэн аж ахуйн нэгжүүдийн бизнес эрхлэх орчин нөхцлийг бүрдүүлэх
- 1.5 Бизнес хөгжлийн төвийг засварлан иргэн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулах таатай нөхцөл бүрдүүлэх

2. ХОТ БАЙГУУЛАЛТ – ХӨГЖЛИЙН ГАРЦ

- 2.1 Баянтээг багийг АО302 замтай хатуу хучилттай замаар холбоно
- 2.2 Сумын төвд 4 км үерийн далан байгуулах
- 2.3 Ерөнхий боловсролын сургуулийн 100 хүүхдийн хичээлийн байр шинээр барих
- 2.4 ЕБС-ийн 80 хүүхдийн дотуур байранд их засвар хийх
- 2.5 Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны дотор их засвар
- 2.6 Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байрны хатуу зөөлөн эдлэлийг шинэчлэх
- 2.7 Сумын төвд спорт заал шинээр барих
- 2.8 Ерөнхий боловсролын сургуулийн ширээ сандалыг шинэчлэх
- 2.9 Сумын төвийн шинэчлэл төслийн ажлыг сумын төвд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, баянтээг багийг Сумын төвийн шинэчлэл төсөлд хамруулах
- 2.10 Сумын төв, баянтээг багийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
- 2.11 Таацын голд Тээл, Цагаан толгойд гүүр барих
- 2.12 Соёлын төвийн өргөтгөл барих, техник хэрэгслээр хангах
- 2.13 Сумын төв, Баянтээг багийн хогийн цэгийг ангилан ялгалт хийх

зориулалт бүхий болгон тохижуулах

3. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ – ЭРҮҮЛ ХҮНС

- 3.1 Суманд мал нядалгааны цех байгуулах
- 3.2 Мал аж ахуй гахай, тахиа, өвлийн хүлэмж зэрэг Фермерийн аж ахуйг хөгжүүлэх
- 3.3 Атаршсан талбайг эргэлтэд оруулж малын тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээг бүрэн хангах

4. БАЙГАЛЬ ОРЧИН – НОГООН ХОТ

- 4.1 Тэр бум мод үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- 4.2 Сумын төв, Баянтээг багт Ногоон байгууламж бүхий Цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тохижуулах

5. НИЙГМИЙН БОДЛОГО – ХҮНИЙ ХӨГЖИЛ

- 5.1 Төрийн албан хаагчийн орон сууц сумын төв, Баянтээг багт барих
- 5.2 Баянтээг багт хөлбөмбөг, сагсан бөмбөг, хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх иж бүрэн тоглоомын талбай байгуулах
- 5.3 Залуучуудын хөгжлийн төв байгуулах
- 5.4 Бүх багуудыг үүрэн телефоны сүлжээнд холбох
- 5.5 Иргэдийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдрах арга ухаанд сургах, орчин бүрдүүлэх

6. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ – ИРГЭН ТАНД

- 6.1 Төрийн үйлчилгээг цахимжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх

Handwritten signature

- 6.2 Иргэнд төрийн үйлчилгээг хурдан шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэх
- 6.3 Иргэнд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл бололцоог сайжруулах зорилгоор техник тоног төхөөрөмжөөр хангах
- 6.4 Сумын ЗДТГ-ын барилгын өргөтгөл барих, тохижуулах
- 6.5 Сумын төвийн төв талбайг иргэдийн амрах орчин болгож тохижуулах
- 6.6 Сумын төвд эрэн хайх аврах анги байгуулах



НАРИЙНТЭЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

Handwritten signature